

Тайлангийн маягт, хавсралт мэдээ,
нөхөх заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, 8.4, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хувь хүний орлогын албан татварын хялбаршуулсан тайлан”-гийн маягт /ТТ-06-ХГ/-ыг 1 дүгээр, “Хувь хүний орлогын албан татварын хялбаршуулсан тайлангийн маягтыг нөхөх заавар”-г 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хавсралтаар батлагдсан тайлангийн маягт, хавсралт мэдээний загварыг Татварын удирдлагын нэгдсэн системд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Татвар төлөгчид үйлчлэх газар /Д.Хүрэлчулуун/, Мэдээллийн технологийн төв /Х.Батбаяр/-д даалгасугай.

3. Батлагдсан маягтын дагуу тайланг хүлээн авч, татварын тооцоо хийхийг Том татвар төлөгчийн газар, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЗАЯАБАЛ



Татварын ерөнхий газрын даргын
20... оны ... сарын ... -ны өдрийн
... дугаар тушаалын ... хавсралт

МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА Маягт ТТ-06-ХГ

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХЯЛБАРШУУЛСАН ТАЙЛАН

ТТ-ийн дугаар:

Утас:

ТТ-ийн нэр:

Факс:

Тайлант хугацаа: он улирал

Тухайн тайлант хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй бол энд тэмдэглэнэ үү.

(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	Мөр	Дүн
I	II	III
А. Хялбаршуулсан горим ашиглан ногдуулах албан татварын тооцоолол:		
1. Үйл ажиллагааны нийт орлого (2+3+4+5+6)	1	
1.1. Бие даан эрхэлсэн мэргэжлийн ажил, үйлчилгээний орлого	2	
1.2. Хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, зүүчлалын үйл ажиллагаа эрхэлж олсон орлого	3	
1.3. Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого	4	
1.4. Эрхэлж байгаа үйл ажиллагаатай холбоотойгоор үнэ төлбөргүй бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээний орлого	5	
1.5. Тогтмол бус үйл ажиллагааны орлого	6	
2. Татвар ногдуулах орлого (мөр 1)	7	
3. ТӨЛБӨЛ ЗОХИХ АЛБАН ТАТВАР (7* хуулийн 21.3-т заасан хувиар)	8	

Тайланг үнэн зөв гаргасан:

Тайланг хүлээн авсан:

Захирал /дарга/

Татварын улсын байцаагч

Ерөнхий нягтлан бодогч

Итгэмжлэгдсэн нягтлан бодогч /...../

Татварын тайлан, хавсралт мэдээг
Татварын удирдлагын нэгдсэн системээс
үүсгэсэн кодоор баталгаажуулна.

Хувь хүний орлогын албан татварын хялбаршуулсан тайлангийн маягтыг нөхөх заавар

Энэхүү тайлангийн маягтаар Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасны дагуу албан татвар төлөгч нь Хувь хүний орлогын албан татварын хялбаршуулсан тайлан /цаашид “тайлан” гэх/-г дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.

Тайланг гаргахдаа Татварын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “Татварын тайлан үйлдэх, тушаах, хүлээн авах, боловсруулах, тайланд залруулга хийх журам”-ыг баримтална. Тайлангийн 3 дугаар баганад тухайн үзүүлэлтийн дүнг өссөн дүнгээр, төгрөгөөр бөглөнө.

Нэг.Хялбаршуулсан горим ашиглан ногдуулах албан татварын тооцоолол

1.Үйл ажиллагааны нийт орлого буюу 1 дүгээр мөрийн дүн нь 2, 3, 4, 5, 6 дугаар мөрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.

2.Бие даан эрхэлсэн мэргэжлийн ажил, үйлчилгээний орлого буюу 2 дугаар мөрийн дүн нь хуулийн 8.1.1-д заасан орлогын дүн байна.

3.Хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, зуучлалын үйл ажиллагаа эрхэлж олсон орлого буюу 3 дугаар мөрийн дүн нь хуулийн 8.1.2-т заасан орлогын дүн байна.

4.Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого буюу 4 дүгээр мөрийн дүн нь хуулийн 8.1.3-т заасан орлогын дүн байна.

5.Эрхэлж байгаа үйл ажиллагаатай холбоотойгоор үнэ төлбөргүй бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээний орлого буюу 5 дугаар мөрийн дүн нь хуулийн 8.1.4-т заасан орлогын дүн байна.

6.Тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлого буюу 6 дугаар мөрийн дүн нь хуулийн 8.2-т заасан орлогын дүн байна.

7.Татвар ногдуулах орлого буюу 7 дугаар мөрийн дүн нь 1 дүгээр мөрийн дүнтэй тэнцүү байна.

8.Төлбөл зохих албан татвар буюу 8 дугаар мөрийн дүн нь 7 дугаар мөрийн дүнг хуулийн 21.3-т заасны дагуу албан татвар ногдуулах орлогыг 1 хувиар үржүүлж гаргасантай тэнцүү байна.